



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/34

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2018 оны 03 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сургуульд улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 62,327,900 (Жаран хоёр сая гурван зуун хорин долоон мянга есөн зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий хоол, хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, 22,086,900 (Хорин хоёр сая наян зургаан мянга есөн зуун) төгрөгийн төсөвт өртөгтэй үдийн цай нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар, 35,000,000 (Гучин таван сая) төгрөгийн төсөвт өртөгтэй түлш, халаалтын материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Арбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал (Л.Даваадорж)-д үүрэг болгосугай.


ДАРГА



Л.ГАНБОЛД

0111057 d/zahiramj

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр  
сарын 17 -ны өдрийн А/34 дүгээр  
захирамжийн 01 дүгээр хавсралт



АРБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД  
ХООЛ, ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-62,327,900 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга


Гишүүд: В.Олдох-Аймгийн Хүнсчдийн холбооны дарга

Ж.Балдандорж-Аймгийн Ногоочдын холбооны дарга

З.Отгонбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Н.Шинэбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр  
сарын 17-ны өдрийн А/34 дүгээр  
захирамжийн 02 дугаар хавсралт



АРБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД  
ҮДИЙН ЦАЙ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ  
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-22,086,900 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга


Гишүүд: В.Олдох-Аймгийн Хүнсчдийн холбооны дарга

Ж.Балдандорж-Аймгийн Ногоочдын холбооны дарга

З.Отгонбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Н.Шинэбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр  
сарын 17 -ны өдрийн А/34 дүгээр  
захирамжийн 03 дугаар хавсралт



АРБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД  
ТҮЛШ, ХАЛААЛТЫН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-35,000,000 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: В.Олдох-Аймгийн Хүнсчдийн холбооны дарга

Ж.Балдандорж-Аймгийн Ногоочдын холбооны дарга

З.Отгонбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Н.Шинэбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хэлтсийн дарга